

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/119/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70274302 Цахим хаяг: saranchimeg.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
Аудитаар алдаа илрээгүй болно.....	19
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/НЗ
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА В.БОЛОРТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, тооллого тооцоог түргэн шуурхай, богино хугацаанд гүйцэтгэх зорилгоор 770.0 мянган төгрөгийн үнэтэй нярвын программ, 1,100.0 мянган төгрөгийн үнэтэй бар код хэвлэгч худалдан авч, хөрөнгө нэг бүрд бар кодтой болгосон. Албан хаагчдын интернэтийг сайжруулж, "Старлинк" төхөөрөмжийг өөрийн байрандаа суурилуулан ашиглаж байна. Тамгын газрын барилга шатсаныг засварлаж дуусган, тайлант онд нүүдэл хийж ажилчдын ашиглаж байсан ширээ, сандал, компьютер, тоног төхөөрөмж муудсан байсныг орон нутгийн шилжих үлдэгдлээс тавилга эд хогшилд 20,291.3 мянган төгрөг, компьютер тоног төхөөрөмжид 20,136.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Сумын 2024 оны төсвийг тодотгон батлах тухай" 02 дугаар тогтоолоор 154,233.2 мянган төгрөгөөр нэмж тодотгон зардлын дээд хэмжээг 1,414,430.6 мянган төгрөгөөр баталсныг бүрэн санхүүжүүлсэн байна.

41250-253

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 зорилт, 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 92,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,723,613.5	110,550,585.7
33	АВЛАГА	0.0	63,472.2
335	Бусад авлага	0.0	63,472.2
3351	Байгууллагаас авах авлага	0.0	63,472.2
35	БАРАА МАТЕРИАЛ	109,723,613.5	110,487,113.5
351	Түүхий эд материал	6,393,889.0	6,393,889.0
35110	Тусгай зориулалттай материал	6,393,889.0	6,393,889.0
354	Хангамжийн материал	103,329,724.5	104,093,224.5
35410	Бичиг хэргийн материал	1,148,400.0	1,329,600.0
35420	Аж ахуйн материал	1,937,300.0	2,649,800.0
35430	Сэлбэг хэрэгсэл	38,336,500.0	36,460,000.0
35440	Түлш, шатах тослох материал	7,772,800.0	7,524,800.0
35450	Барилгын засварын материал	5,405,100.0	6,050,500.0
35470	Бусад хангамжийн материал	48,729,624.4	50,078,524.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,497,909,939.5	5,606,032,865.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,497,909,939.5	5,606,032,865.4
392	Биет хөрөнгө	3,304,409,139.5	5,116,248,465.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,342,965,447.3	2,883,447,301.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	-531,849,175.1	-646,274,175.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	602,801,346.6	1,936,850,346.6
39204	Хуримтлагдсан элэгдэл	-343,568,559.2	-384,467,089.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	334,435,736.2	445,188,098.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,745,385.6	-215,763,023.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,164,634.0	171,465,833.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,816,233.3	-63,429,029.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,415,566,042.0	1,562,655,222.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-435,544,713.4	-573,425,017.1
393	Биет бус хөрөнгө	193,500,800.0	489,784,400.0
39301	Программ хангамж	3,450,000.0	4,220,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.0	-750,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	190,500,800.0	486,314,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,607,633,553.0	5,716,583,451.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	3,999,379.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	3,999,379.0
413	Өглөг	0.0	3,999,379.0
4136	Бусад өглөг	0.0	3,999,379.0
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	3,999,379.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,607,633,553.0	5,712,584,072.1
51	Засгийн газрын хувь оролцоо	3,607,633,553.0	5,712,584,072.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	460,393,479.7	460,393,479.7
51101	Өмч: - төрийн	460,393,479.7	460,393,479.7
512	Хуримтлагдсан үр дүн	2,436,389,020.2	4,541,339,539.3
51210	Өмнөх үеийн үр дүн	2,436,389,020.2	2,436,389,020.2
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	2,104,950,519.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	710,851,053.1	710,851,053.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI	3,607,633,553.0	5,716,583,451.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,108,267,708.0	3,808,362,310.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,162,334,168.0	2,044,691,247.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,162,334,168.0	2,044,691,247.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,162,334,168.0	2,044,691,247.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	945,933,540.0	1,763,671,062.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	898,412,200.0	1,414,430,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,521,340.0	349,240,462.5
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах төсвийн захира	0.0	79,234,212.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусг	42,410,340.0	265,699,750.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа	5,111,000.0	4,306,500.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,092,123,256.3	1,618,741,885.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,092,123,256.3	1,618,741,885.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,019,739,425.4	1,315,187,590.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,347,911.4	668,752,249.9
210101	Үндсэн цалин	260,936,804.7	347,806,936.3
210102	Нэмэгдэл	119,011,620.6	251,109,349.9
210104	Урамшуулал	21,572,051.2	9,887,550.0
210105	Гэрээт ажлын хөлс	52,827,434.9	59,948,413.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши	58,457,029.0	84,233,426.8
210201	Тэтгэврийн даатгал	39,726,166.2	57,514,600.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,684,789.9	6,852,822.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,877,947.1	3,386,295.4
210204	Ажилгүйдлийн даатгал	936,998.0	3,277,505.2
210205	Эрүүл мэндийн даатгал	9,231,127.8	13,202,202.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зард	64,892,515.6	95,416,014.6
210301	Гэрэл, цахилгаан	17,922,213.7	30,309,909.6
210302	Түлш, халаалт	46,970,301.9	65,106,105.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,777,391.3	45,837,623.0
210401	Бичиг хэрэг	2,810,400.0	3,177,300.0
210402	Тээвэр, шатахуун	16,091,847.5	23,039,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,175,000.0	2,100,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч	15,261,374.7	17,521,323.0
210408	Бараа материал акталсны зардал	1,438,769.0	0.0
2105	Норматив зардал	969,900.0	1,728,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	969,900.0	1,728,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,339,886.9	9,743,350.0
210604	Урсгал засвар	1,339,886.9	9,743,350.0
2107	Томилолт, зочны зардал	2,512,000.0	7,439,000.0
210702	Дотоод албан томилолт	2,512,000.0	7,439,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	5,701,530.0	21,725,351.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	3,977,990.0	16,956,564.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	1,008,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,540.0	434,960.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.0	154,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	976,800.0
210807	Газрын төлбөр	0.0	1,195,027.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394,741,261.3	380,311,775.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,847,690.0	26,177,506.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	361,997,537.6	354,134,269.1

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,383,830.9	303,554,295.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,749,000.0	17,423,679.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,027,300.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө	16,749,000.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажи	0.0	8,754,979.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	2,641,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүл	54,634,830.9	286,130,615.5
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,634,830.9	286,130,615.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,006,040,485.4	2,189,620,425.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	84,669,906.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.0	-84,669,906.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,006,040,485.4	2,104,950,519.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	945,933,540.0	1,763,671,062.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	945,933,540.0	1,763,671,062.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	898,412,200.0	1,414,430,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	898,412,200.0	1,414,430,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,521,340.0	349,240,462.5
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй ху	0.0	79,234,212.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусга	42,410,340.0	265,699,750.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаан	5,111,000.0	4,306,500.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	729,213,916.0	1,271,439,882.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	729,213,916.0	1,271,439,882.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,830,085.1	967,373,115.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,347,911.4	668,752,249.9
210101	Үндсэн цалин	260,936,804.7	347,806,936.3
210102	Нэмэгдэл	119,011,620.6	251,109,349.9
210104	Урамшуулал	21,572,051.2	9,887,550.0
210105	Гэрээт ажлын хөлс	52,827,434.9	59,948,413.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	58,457,029.0	84,233,426.8
210201	Тэтгэврийн даатгал	39,726,166.2	57,514,600.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,684,789.9	6,852,822.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,028,265.1	3,386,295.4
210204	Ажилгүйдлийн даатгал	936,998.0	3,277,505.2
210205	Эрүүл мэндийн даатгал	9,080,809.8	13,202,202.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,273,315.6	95,168,014.6
210301	Гэрэл, цахилгаан	17,922,213.7	30,309,909.6
210302	Түлш, халаалт	51,351,101.9	64,858,105.0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,689,372.3	45,988,223.2
210401	Бичиг хэрэг	3,499,600.0	3,327,900.0
210402	Тээвэр, шатахуун	15,383,397.5	23,039,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	17,631,374.7	17,521,323.2
2105	Нормативт зардал	996,900.0	1,992,300.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	996,900.0	1,992,300.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,297,386.9	13,478,250.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	2,287,000.0
210602	Тавилга	0.0	1,193,000.0
210604	Урсгал засвар	2,297,386.9	9,998,250.0
2107	Томилолт, зочны зардал	2,512,000.0	7,439,000.0
210702	Дотоод албан томилолт	2,512,000.0	7,439,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,717,130.0	25,775,951.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	3,993,590.0	20,206,564.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	1,008,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,540.0	434,960.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.0	184,600.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	1,746,800.0
210807	Газрын төлбөр	0.0	1,195,027.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,539,040.0	24,545,700.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,539,040.0	24,545,700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,383,830.9	304,066,767.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,749,000.0	17,936,151.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,539,772.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө	16,749,000.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай аж	0.0	8,754,979.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	2,641,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,634,830.9	286,130,615.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,634,830.9	286,130,615.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)	216,719,624.0	492,231,180.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	216,719,624.0	492,231,180.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	216,719,624.0	492,231,180.0
2200	Дотоод эх үүсвэрээр	216,719,624.0	492,231,180.0
221001	Их засвар	0.0	2,420,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зард	216,719,624.0	489,811,180.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭ	-216,719,624.	-492,231,180.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31	460,393,479.7	710,944,084.3	1,428,345,663.7	2,599,683,227.6
C03	Дахин илэрхийлсэн үлд	460,393,479.7	710,944,084.3	1,428,345,663.7	2,599,683,227.6
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,006,040,485.4	1,006,040,485.4
C08	2023 оны 12-р сарын 31	460,393,479.7	710,851,053.1	2,436,389,020.2	3,607,633,553.0

D01	2023 оны 12-р сарын 31	460,393,479.7	710,851,053.1	2,436,389,020.2	3,607,633,553.0
D03	Дахин илэрхийлсэн үлд	460,393,479.7	710,851,053.1	2,436,389,020.2	3,607,633,553.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,104,950,519.1	2,104,950,519.1
D09	2024 оны 12-р сарын 31	460,393,479.7	710,851,053.1	4,541,339,539.3	5,712,584,072.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,180,063,400.0	917,660,512.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,180,063,400.0	917,660,512.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,170,655,400.0	908,479,340.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,998,200.0	599,204,924.0
210101	Үндсэн цалин	392,109,300.0	347,806,936.3
210102	Нэмэгдэл	248,877,600.0	181,562,024.0
210104	Урамшуулал	26,511,300.0	9,887,550.0
210105	Гэрээт ажлын хөлс	80,500,000.0	59,948,413.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ц	93,500,100.0	75,586,442.4
210201	Тэтгэврийн даатгал	63,579,900.0	51,621,527.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,480,000.0	6,157,349.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,740,100.0	3,058,874.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,740,100.0	2,935,365.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,960,000.0	11,813,325.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зард	102,455,800.0	95,168,014.6
210301	Гэрэл, цахилгаан	37,394,700.0	30,309,909.6
210302	Түлш, халаалт	64,861,100.0	64,858,105.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	93,726,200.0	40,846,723.2
210401	Бичиг хэрэг	3,338,000.0	3,327,900.0
210402	Тээвэр, шатахуун	23,504,200.0	17,897,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,134,000.0	2,100,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчд	64,750,000.0	17,521,323.2
2105	Норматив зардал	1,992,300.0	1,992,300.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,992,300.0	1,992,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,500,000.0	43,193,449.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.0	7,500,000.0
210602	Тавилга	27,000,000.0	25,695,199.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	9,998,250.0
2107	Томилолт, зочны зардал	7,311,000.0	6,589,000.0
210702	Дотоод албан томилолт	7,311,000.0	6,589,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураа	31,008,000.0	23,819,387.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлч	18,250,000.0	18,250,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогто	1,008,000.0	1,008,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.0	434,960.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250,000.0	184,600.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.0	1,746,800.0
210807	Газрын төлбөр	2,500,000.0	1,195,027.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,163,800.0	22,079,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,163,800.0	22,079,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,408,000.0	9,181,172.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,408,000.0	9,181,172.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.0	6,539,772.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.0	2,641,400.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	267,250,000.0	208,757,783.0
2200	Дотоод эх үүсвэрээр	267,250,000.0	208,757,783.0
221001	Их засвар	142,960,000.0	98,742,483.0
222001	Тоног төхөөрөмж	24,028,000.0	23,913,800.0
223001	Бусад хөрөнгө	100,262,000.0	86,101,500.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,447,313,400.0	1,414,430,600.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН	1,447,313,400.0	1,414,430,600.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35	35
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	13	13
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35	35
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
650010	Гэрээт ажилтан	13	13
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,521,340.00	349,240,462.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,521,340.00	104,252,264.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,401,738.88	92,279,274.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,149,014.52	69,547,325.88
210102	Нэмэгдэл	25,000,140.27	69,547,325.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,893,626.84	8,646,984.44
210201	Тэтгэврийн даатгал	2,647,666.24	5,893,073.79
210202	Тэтгэмжийн даатгал	311,490.17	695,473.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	529,565.41	327,420.53
210204	Ажилгүйдлийн даатгал	62,298.03	342,140.18
210205	Эрүүл мэндийн даатгал	342,606.99	1,388,876.72
2104	Хангамж, бараа материалын зардал	819,997.52	5,141,500.00
210402	Тээвэр, шатахуун	819,997.52	5,141,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал		850,000.00
210702	Дотоод албан томилолт		850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,194,000.00	1,956,564.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ү	1,194,000.00	1,956,564.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,345,100.00	4,936,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,345,100.00	4,936,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,754,979.50
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,754,979.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажил		8,754,979.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,119,601.12	3,218,010.68
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт с		30,016.68
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч	6,119,601.12	3,187,994.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		244,988,198.00
2200	Дотоод эх үүсвэрээр		169,000,000.00
222001	Тоног төхөөрөмж		75,988,198.00
223001	Бусад хөрөнгө	47,521,340.00	349,240,462.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,521,340.00	349,240,462.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		79,234,212.00
131103	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй	42,410,340.00	265,699,750.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт шат	5,111,000.00	4,306,500.00
131105	Төсвийн байгууллагын хүрээнд бий болсон н	47,521,340.00	349,240,462.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 25 зорилт, хэрэгжүүлэх 95 арга хэмжээ баталж нийт 92,0 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 35 орон тоо батлагдсанаас удирдах 7, гүйцэтгэх 15, үйлчилгээний 13 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, удирдлагын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд үзүүлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод зохион байгуулж ажиллуулах зорилтын хүрээнд сумын тогтвортой урт хугацааны хөгжлийн зорилтыг тодорхойлж, эдийн засаг, санхүүгийн чадавхыг бэхжүүлж, хөрөнгө оруулалт, өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах замаар ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай ажлыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 27-ний өдрийн А/13 дугаар захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар 2024 оны санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,108,949.9 мянган төгрөгөөр буюу 58,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	63.5	63.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	109,723.6	110,487.1	763.5
Үндсэн хөрөнгө	3,497,909.9	5,606,032.9	2,108,122.9
Нийт хөрөнгө	3,607,633.6	5,716,583.5	2,108,949.9
Өр төлбөр	-	3,999.4	3,999.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,607,633.6	5,712,584.1	2,104,950.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,607,633.6	5,716,583.5	2,108,949.9

Дээрх хүснэгтээс харахад: Авлага данс 63.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь албан хаагчдын хувь хүний орлогын албан татварыг илүү шилжүүлснээс шалтгаалжээ. Өглөг данс 3,999.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох 79,987.6 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийн баталгааг үүссэнээс шалтгаалжээ.

Бараа материал дансны хувьд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 102,634,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 30,438.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 4,105.6 мянган төгрөгийн шатахуун, 27,767.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал материал тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, 140,543.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ. Нийт зарцуулалтын 35,841.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй зарлагдсан нь МУЗГ-ын 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолоор сумын мал бүхий иргэдэд өрхийн эмчийн цүнх, эмийн багц, тэжээлийн будаа, цагаан будаа, шатахуун, загасан тос, хуурай глюкоз, шархны тос, ногоон тэжээл, гурил зэргийг мал бүхий иргэдэд тараасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 2024 онд 2,511,085.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 48,828.0 мянган

төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр барилга байгууламж дансанд 106,930.1 мянган төгрөгийн Гэр хорооллын айл өрхийн дулааны шугам, авто тээврийн хэрэгсэл дансанд 176,460.0 мянган төгрөгийн шавар зуурагч машин, Hyundai County автобус, 51,174.8 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 21,161.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 148,571.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 770.0 мянган төгрөгийн программ хангамж нийт 505,067,1 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 433,551.8 мянган төгрөгийн байгууламж, Төв аймгийн ХХААГ болон ХХААХҮЯ-аас төмс хураах комбайн 1,157,589.0 мянган төгрөгийн 6 авто тээврийн хэрэгсэл, ОНХС-гийн хөрөнгөөр 61,250.0 мянган төгрөгийн бохирын сентик, усны иж бүрэн зөөлрүүлэгч төхөөрөмж, ХХААГ-аас 17,500.0 мянган төгрөгийн бүх төрлийн үрсэлгээ суулгагч, ХХААХҮЯ болон аймгийн ЗДТГ-аас dell компьютер, зэрэг нийт 83,605.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Алтай таван мандал ХХК-аас 3,200.0 мянган төгрөгийн 5 ханатай иж бүрэн гэр, тооллогоор илрүүлсэн 8,940.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ОНХС-аас 23,318.2 мянган төгрөгийн явган зам, 295,813.6 мянган төгрөгийн 15 газар эзэмших эрхийг тус тус үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,712,584.1 мянган төгрөг болж 2,104,950.5 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,260,297.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 0.3 мянган төгрөгөөр нэмж 2024 оны урсгал зардлын төсвийг 1,260,197.4 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анхны батлагдсан төсөв 1,260,197.4 мянган төгрөгөөс Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Сумын 2024 оны төсвийг тодотгон батлах тухай" 02 дугаар тогтоолоор 154,233.2 мянган төгрөгөөр нэмж тодотгон 1,414,430.6 мянган төгрөгийн санхүүжилтийг баталж бүрэн санхүүжүүлсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,414,430.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 282,912.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,131,518.0 мянган төгрөг буюу 80,0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 80101/үндсэн үйл ажиллагааны зардал	658,017.9	568,059.2	89,958.7	86.3
2	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 80103/гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	93,302.0	47,840.7	45,461.3	51.3
3	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 80106/баг хорооны үйл ажиллагааны зардал	311,421.7	257,764.0	53,657.7	82.8
4	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 80802/ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал	2,800.0	2,641.4	158.6	94.3

5	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 80918/бусад хөрөнгийн зардал	267,250.0	208,757.8	58,492.2	78.1
6	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 81102/Орон нутгийн нөөц хөрөнгө	7,500.0	6,580.0	920.0	87.7
7	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 82609/ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	6,608.0	6,539.8	68.2	99.0
8	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/ 82801/Улсын их баяр наадмын зардал	5,000.0	4,022.5	977.6	80.4
9	71411-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ 81701/Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	24,531.0	11,791.4	12,739.7	48.1
10	71411-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ 82212/хур хог хаягдал, орчны бохирдол	38,000.0	17,521.3	20,478.7	46.1
	Дүн	1,414,430.6	1,131,518.0	282,912.6	80.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс 79,234.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 265,699.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,306.5 мянган төгрөг нийт 349,240.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 78,194.3 мянган төгрөг, шатахууны зардалд 5,141.5 мянган төгрөг, малын түүвэр судалгааны урамшуулал 1,956.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 1,200.0 мянган төгрөгийн өнгөт хэвлэгч, дотоод томилолтын зардалд 850.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,936.9 мянган төгрөгийн гэрийн бүрээс, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 8,755.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 244,988.2 мянган төгрөгийн нийт 346,022.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн нэмэгдлийн зардал 50.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын 63.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын хүрээнд бий болсон орлогоос 3,106.5 мянган төгрөгийн өвсний үнэ, тендерийн орлого, дансны лавлагааны үнэ зэрэг зарцуулагдаагүй буюу нийт 3,218.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1	Хөтөлбөрийн хэрэгжилт 92.0%	1,351,899.60	1,102,205.32

	засаглалын удирдлага		хөтөлбөрийн 7 арга хэмжээ хэрэгжүүлэх			
2	71411- Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92.0%	62,531.00	29,312.67
			Дүн		1,414,430.60	1,131,518.00

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 23,504.2 мянган төгрөгийн шатахуун, 280,504.2 мянган төгрөгийн үүнд: хүүхдийн автобус 70,000.0 мянган төгрөг, гэр хорооллыг дулаанаар холбох ажил 80,000.0 мянган төгрөг, шавар зурагч машин 108,000.0 мянган төгрөг, Тамгын газрын бусад зардал 22,504.2 мянган төгрөг зэрэг ажлыг харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд гэрэл цахилгааны зардал, нэгдсэн халаалтын зардал, бичиг хэрэг болон тамгын газрын урсгал зардал, газрын нэгдмэл сангийн зураг төсөв, болон бусад хөрөнгө оруулалтын ажлууд зэрэг бараа ажил үйлчилгээг тус тус шууд худалдан авалтаар нийт 364,429.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 280,504.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар, 264,429.5 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардал, нэгдсэн халаалтын зардал, бичиг хэрэг болон тамгын газрын урсгал зардал, мөн эмнэлгийн уулзвараас дотуур байр хүртэлх сайжруулсан зам засвар 18,000.0 мянган төгрөг, үерийн далангийн шуудуу засвар 19,000.0 мянган төгрөг, Баянбулаг цэцэрлэгт халаалтын тогоо худалдан авах 13,000.0 мянган төгрөг, ЕБС-ийн спорт заалтын хана засварын ажлын хөлс 8,000.0 мянган төгрөг, ЕБС-ийн спорт заалны тааз засвар 16,800.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн зам талбайн засварын ажил 17,700.0 мянган төгрөг, гудамжны гэрэлтүүлэг шинээр тавих 19,800.0 мянган төгрөг, гудамжны гэрэлтүүлэг засвар 19,800.0 мянган төгрөг, үдийн цайны тоног төхөөрөмж худалдан авах 11,300.0 мянган төгрөг, авто машины засварт 15,000.0 мянган төгрөг, Өгөөмөр 2-р багт хүүхдийн тоглоомын талбайн бетон зуурмаг 10,000.0 мянган төгрөг, Тамгын газарт тоног төхөөрөмж худалдан авахад 19,500.0 мянган төгрөг, тавилга худалдан авах 12,000.0 мянган төгрөг, ойжуулалтын ажилд 6,000.0 мянган төгрөг, интернэтийн тоног төхөөрөмж худалдан авахад 5,000.0 мянган төгрөг зэрэг бараа ажил үйлчилгээг тус тус шууд худалдан авалтаар нийт 264,429.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийж, 280,504.2 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний худалдан авалт нь тендерт шалгаруулсан байна.

3.5.6 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газарт 2024 онд орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл батлагдаагүй байна.

3.5.7 Судалгааны үр дүн

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний данс /210801/-ны хувьд нийт үндсэн санхүүжилтийн данснаас 8,250.0 мянган төгрөг, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардал данс /80101/-ны хувьд 3,250.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх данс /82801/-ны хувьд 1,093.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 5,811.0 мянган төгрөг, үүнээс малын өвс тэжээлийн зардал /81305/-ын хувьд 4,640.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого /81526/-ны хувьд 1,171.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын хувьд нийт үндсэн санхүүжилтийн данснаас 48,311.9 мянган төгрөг, үүнээс орон нутгийн нөөц хөрөнгө данс /81102/-ны хувьд 4,250.0 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх данс /81701/-ны хувьд 43,863.9 мянган

төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 55,754.3 мянган төгрөг, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардал данс /80101/-ны хувьд 25,000.0 мянган төгрөг, өвс тэжээлийн нөөц данс /81305/-ны хувьд 30,754.3 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Орон тооны хувьд тайлант онд 35 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 35, үүнээс удирдах 7, гүйцэтгэх 15, үйлчилгээний 13 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар 2024 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар 2024 оны баталсан төсвийн нийт зарлага 1,618,741.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 15,775.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12,620.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардал гаргаагүй боловч авлага 63.5 мянган төгрөг, өр төлбөр 3,999.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалтаар 12 мэдээлэл, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 12 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэх 55 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 12, зарлагын гүйлгээ 12, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 41 мэдээлэл болон бусад мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан 159 мэдээллийг хугацаанд нь байршуулж хэрэгжилт 100% байна. Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалтыг хийсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн хэмнэлттэй холбоотой 1 төлбөрийн акт, төлбөрийн цахим баримттай холбоотой 1 албан шаардлага, хөрөнгийн зардал, хөрөнгийн тооллогын бүртгэл, газар эзэмших эрхийн бүртгэлтэй холбоотой зэрэг 8 зөвлөмжийг 78,3 %-ийг хэрэгжүүлэн Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 03/283 дугаар албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	11,337.1	1	11,337.1	100.00
Албан шаардлага	1	26,006.6	1	26,006.6	100.00
Зөвлөмж	8	1,029,862.2	8	358,584.6	34.82
Нийт дүн	10	135,350.8	10	135,350.8	78.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн заавар, журам шинэчлэгдсэнийг хэрэгжүүлж байгаа эсэхийг авч үзэх. Мөн 2024 онд ХХААГ болон ХХААХҮЯ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн техник хэрэгслийн ашиглалтын байдал, бараа материал, хөрөнгийн тооллогын үр дүнг нягталж үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй болно.

Залруулагдаагүй нийт 17,375.5 мянган төгрөгийн зөрчлөөс 875.5 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,900.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 875.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 875.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

Залруулаагүй алдаа:

Төлбөрийн акт

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгосон мөнгөн урамшуулал 8,754.9 мянган төгрөгөөс ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 22 дугаар зүйлийн 22.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Сэлбэг хэрэгслийн данс бүртгэлд байгаа Ланд 105 мотор 5,0 сая төгрөг, Ковш мотор 11,5 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг автомашинд тавьж ашиглаж байгаа тул тээврийн хэрэгслийг капиталжуулж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгосон мөнгөн урамшуулал 8,754.9 мянган төгрөгөөс ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон байна.	1	875.5	1	875.5	-	-	-	-
2	Сэлбэг хэрэгслийн данс бүртгэлд байгаа Ланд 105 мотор 5,0 сая төгрөг, Ковш мотор 11,5 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг автомашинд тавьж ашиглаж байгаа тул тээврийн хэрэгслийг капиталжуулж бүртгээгүй байна.	1	16,500.0	-	-	1	16,500.0	-	-
Нийт дүн		2	17,375.5	1	875.5	1	16,500.0	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn